



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 21 өдөр

Лугаар 90

Улаанбаатар хот

Г  
Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл, 05 дугаар зүйлийн 05.0 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолын хавсралтуудад дараах өөрчлөлт оруулсугай.

1.1. Тогтоолын 1-р хавсралтаар баталсан "Төрийн захирагааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсгийн "Тэргүүн түшмэлийн" гэснийг "Эрхэлсэн түшмэлийн" гэж, Туршлага хэсгийн "16-аас" гэснийг "12-oos" гэж, "8-аас" гэснийг "6-аас" гэж;

1.2. Тогтоолын 2-р хавсралтаар баталсан "Төрийн захирагааны албан тушаалын эрхэлсэн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсгийн "Эрхэлсэн түшмэлийн" гэснийг "Ахлах түшмэлийн" гэж, Туршлага хэсгийн "12-oos" гэснийг "8-аас" гэж;

1.3. Тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Төрийн захирагааны удирдах албан тушаалын ахлах түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаал", 5-р хавсралтаар "Төрийн захирагааны гүйцэтгэх албан тушаалын ахлах түшмэл, түүнтэй адилтгах гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсгийн "Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад" гэснийг "Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад" гэж, Туршлага хэсгийн "8-аас" гэснийг "6-аас" гэж, "4-өөс гэснийг "3-аас" гэж;

1.4. Тогтоолын 4-р хавсралтаар батлагдсан "Төрийн захирагааны удирдах албан тушаалын дэс түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсгийн "Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг "Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж төгссөн байх" тус тус өөрчилсүгэй.

2. Тогтоолын 6-р хавсралтаар батлагдсан "Төрийн захирагааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэл, түүнтэй адилтгах гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсгийн "Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг хассугай.

3. Төрийн албаны зөвлөлийн холбогдох тогтоолд оруулсан өөрчлөлтийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн удирдлага, мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (Г.Билгүүн)-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах  
удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	-Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй								
Мэргэжил	-Тухайн салбарын болон албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй баях								
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> <li>-Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, тэгссөн байх болно; <i>/Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дүгээр тохиолдоор өөрчлөнө</i></li> <li>-Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх</li> </ul>								
Туршлага	<ul style="list-style-type: none"> <li>-Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх</li> </ul> <p><i>/Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дүгээр тохиолдоор өөрчлөнө</i></p>								
Ур чадвар	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 15%;">Удирдан зохион байгуулах</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Төрийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дагуу тухайн салбарын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих</li> <li>-Төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх</li> <li>-Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх</li> <li>-Эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх</li> </ul> </td> </tr> <tr> <td>Дүн шинжилгээ хийх</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх</li> <li>-Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, зөвлөгөө өгөх</li> </ul> </td> </tr> <tr> <td>Асуудал шийдвэрлэх</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Хуульд нийцсэн шийдвэр гаргах</li> <li>-Оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах</li> <li>-Шийдвэрийн үр дагаварыг урьдчилан тооцоолох</li> <li>-Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх</li> </ul> </td> </tr> <tr> <td>Манлайлах</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Ес зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах</li> <li>-Хувийн зохион байгуулалтын хувьд үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх</li> </ul> </td> </tr> </table>	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>-Төрийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дагуу тухайн салбарын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих</li> <li>-Төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх</li> <li>-Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх</li> <li>-Эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх</li> </ul>	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>-Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх</li> <li>-Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, зөвлөгөө өгөх</li> </ul>	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>-Хуульд нийцсэн шийдвэр гаргах</li> <li>-Оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах</li> <li>-Шийдвэрийн үр дагаварыг урьдчилан тооцоолох</li> <li>-Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх</li> </ul>	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>-Ес зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах</li> <li>-Хувийн зохион байгуулалтын хувьд үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх</li> </ul>
Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>-Төрийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дагуу тухайн салбарын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих</li> <li>-Төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх</li> <li>-Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх</li> <li>-Эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх</li> </ul>								
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>-Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх</li> <li>-Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, зөвлөгөө өгөх</li> </ul>								
Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>-Хуульд нийцсэн шийдвэр гаргах</li> <li>-Оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах</li> <li>-Шийдвэрийн үр дагаварыг урьдчилан тооцоолох</li> <li>-Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх</li> </ul>								
Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>-Ес зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах</li> <li>-Хувийн зохион байгуулалтын хувьд үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх</li> </ul>								

Бусад

-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар<sup>1</sup>

---

<sup>1</sup> Эдгээр ур чадварыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д зааснаар тодорхойлно.

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 02 дугаар  
тогтоолын 2-р хавсралт

Төрийн захиргааны албан тушаалын эрхэлсэн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол		-Яамны газрын дарга түүнтэй адилтгах албан тушаалд: Магистр ба түүнээс дааш боловсролын зэрэгтэй -Яамны хэлтсийн дарга түүнтэй адилтгах бусад албан тушаалд: Бакалавр ба түүнээс доош боловсролын зорогтэй
Мэргэжил		-Тухайн салбарын болон албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх
Мэргэшил		- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх; <i>Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн</i> -Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх
Туршлага		-Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх <i>Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн</i>
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх -Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх -Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгаа хийх -Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах
	Асуудал шийдвэрлэх	-Хуульд нийцсэн шийдвэр гаргах -Оновчтой, шуурхай, ур дүнтэй шийдвэр гаргах -Аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль, тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах -Албан тушаалын бүрэн эрхийн хүрээг баримталж шийдвэр гаргах -Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх
	Манлайлах	-Ес зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх
	Бусад	-Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах

-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар<sup>2</sup>

---

<sup>2</sup> Эдгээр ур чадварыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д зааснаар тодорхойлно.

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 02 дугаар  
тогтоолын 3-р хавсралт

Төрийн захиргааны удирдах албан тушаалын ахлах түшмэл, түүнтэй  
адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагатай

Боловсрол	-Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	-Албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх	
Мэргэшил	-Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх; <i>Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дугаар тогтоолын зорилтуулсан</i> -Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	
Туршлага	-Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх <i>Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дугаар тогтоолын зорилтуулсан</i>	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх
	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх -Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх
	Манлайлах	-Ес зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах -Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх
	Бусад	-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх -Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар <sup>3</sup>

<sup>3</sup> Эдгээр ур чадварыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д зааснаар тодорхойлно.

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 02 дугаар  
тогтоолын 4-р хавсралт

Төрийн захиргааны удирдах албан тушаалын дэс түшмэл, түүнтэй  
адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	-Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй										
Мэргэжил	-Албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх										
Мэргэшил	<ul style="list-style-type: none"> <li>-Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж төгссөн байх <i>(Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дугаар тогтоолоор асуулт оруулав)</i></li> <li>-Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх</li> </ul>										
Туршлага	-Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх										
Ур чадвар	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 15%;">Удирдан зохион байгуулах</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах</li> <li>Удирдлагодоо байгаа албан хаагчидын ажил үүргийг оногчтой хуваарилах, удирдах чадвартай</li> <li>-Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх</li> </ul> </td> </tr> <tr> <td>Дүн шинжилгээ хийх</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх</li> <li>-Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг дүгнэх</li> </ul> </td> </tr> <tr> <td>Асуудал шийдвэрлэх</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх</li> </ul> </td> </tr> <tr> <td>Манлайлах</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах</li> <li>-Байгууллагын үйл ажиллагааны шинэлгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх</li> </ul> </td> </tr> <tr> <td>Бусад</td> <td> <ul style="list-style-type: none"> <li>-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх</li> <li>-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар<sup>4</sup></li> </ul> </td> </tr> </table>	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах</li> <li>Удирдлагодоо байгаа албан хаагчидын ажил үүргийг оногчтой хуваарилах, удирдах чадвартай</li> <li>-Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх</li> </ul>	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх</li> <li>-Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг дүгнэх</li> </ul>	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх</li> </ul>	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах</li> <li>-Байгууллагын үйл ажиллагааны шинэлгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх</li> </ul>	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх</li> <li>-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар<sup>4</sup></li> </ul>
Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах</li> <li>Удирдлагодоо байгаа албан хаагчидын ажил үүргийг оногчтой хуваарилах, удирдах чадвартай</li> <li>-Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх</li> </ul>										
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх</li> <li>-Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг дүгнэх</li> </ul>										
Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх</li> </ul>										
Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх</li> <li>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах</li> <li>-Байгууллагын үйл ажиллагааны шинэлгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх</li> </ul>										
Бусад	<ul style="list-style-type: none"> <li>-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх</li> <li>-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвар<sup>4</sup></li> </ul>										

<sup>4</sup> Эдгээр ур чадварыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д зааснаар тодорхойлно.

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 02 дугаар  
тогтоолын 5-р хавсралт

Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын ахлах түшмэл, түүнтэй  
адилтгах гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол		-Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил		-Албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх
Мэргэшил		<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамраидж төгссин байх; /Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дугаар тогтоолоор зөрчилтэй оруулсан/</li> <li>-Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх</li> </ul>
Туршлага		<ul style="list-style-type: none"> <li>-Төрийн албанад 6-аас доошгүй жил, үүнээс дээс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх /Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дугаар тогтоолоор зөрчилтэй оруулсан/</li> </ul>
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>-Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах</li> <li>-Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах</li> <li>-Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг илрүүлэх</li> <li>-Судалгааны арга зүйн мэдлэгтэй</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах</li> <li>-Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох</li> <li>-Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах</li> <li>-Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар<sup>5</sup></li> </ul>

<sup>5</sup> Эдгээр ур чадварыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д зааснаар тодорхойлно.

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 02 дугаар  
тогтоолын 6-р хавсралт

Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэл, түүнтэй  
адилтгах гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	-Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	-Албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжилтэй байх	
Мэргэшил	<i>Энэ хэсээн Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 90 дүгээр тооцоолоор өөрчлөлт оруулсан.</i> -Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	
Туршлага	-Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно <i>Энэ хэсийн Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 372 дугаар тооцоолоор өөрчлөн наийруулсан.</i>	
Ур чадвар	Дун шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох
	Бусад	-Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар <sup>6</sup>

<sup>6</sup> Эдгэр ур чадварыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д зааснаар тодорхойлно.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ УДИРДАХ,  
ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГЫГ БАТЛАХ ТУХАЙ"  
2 ДУГААР ТОГТООЛЫН ХОЛБОГДОХ ХАВСРАЛТУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2023.03.21

Энэхүү нөлөөллийн шинжилгээг Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4, 61.5 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн A/147 дугаар тушаалын хавсралтын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу хийв.

**Нэг. Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт**

Төрийн албаны шинэтгэлийн үйл явц, хууль тогтоомжийн өөрчлөлт, Ковидын дараах нөхцөл байдал, төрийн байгууллага, албан хаагчид, иргэдээс удаа дараа ирүүлж байгаа хүсэлт, шаардлагаас үзэхэд төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг тогтоол шийдвэрт нийцүүлэн уян хатан болгож өөрчлөх зүй ёсны хэрэгцээ байгаа нь харагдлаа.

**Хууль тогтоомжийн үндэслэл**

1. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 хэсэгт Хуульд өөреөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно:

23.2.1.тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогодох бол төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх;

23.2.2.эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогодох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх;

23.2.3.ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогодох бол төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх." гэж тус тус заасан

Тэгвэл Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолын

- 1-р хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсэгт "Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх",
- 2-р хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын эрхэлсэн түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсэгт "Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх",
- 3-р хавсралтаар баталсан "Төрийн захиргааны удирдах албан тушаалын ахлах түшмэл, түүнтэй адилтгах удирдах албан тушаал", 5-р хавсралтаар "Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын ахлах түшмэл, түүнтэй адилтгах гүйцэтгэх албан тушаалд

тавигдах тусгай шаардлага"-ын Мэргэшил хэсэгт "Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх" гэж тус тус заасан.

2. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоердугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 4.2.4.1-д "бөгөөд" холбоос үгийг аливаа хоёр болон түүнээс дээш зүйлийг нэг зүйлд хамаатуулах тохиолдолд хэрэглэнэ. Тухайлбал, "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч" гэсэн нь дээрх болзлыг зэрэг хангасан гэсэн утга агуулна гэжээ.

3. Төрийн албаны тухай хуульд оруулсан 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн өөрчлөлтөөр төрийн захиргааны албан тушаалын туршлагын шаардлагыг бууруулсан болно.

#### Бодит нөхцөл байдал

1. Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 232, эрхэлсэн түшмэлийн сургалтад 1286, ахлах түшмэлийн сургалтад 4016 хамрагдсан байна. 2022 оны тоо бүртгэлээс харахад тэргүүн түшмэл 166, эрхэлсэн түшмэл 716, ахлах түшмэл 2505 ажиллаж байна. Өөрөөр хэлбэл бодит албан тушаалын тооноос 70-1500 нэгжээр илүү албан хаагч мэргэшүүлэх багц сургалтад хамрагджээ. Гэтэл төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчдын сонгон шалгаруулахад хууль болон албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан албан хаагч, иргэн бүртгэлд хамрагдах байдал эрс цөөрөх хандлагатай байна.

Дээр дурдсан нөхцөл байдлуудыг харгалзан Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 хэсгийн холбогдох заалтад дурдсан төрийн захиргааны зохих ангиллын албан тушаалын тусгай шаардлагын "... бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх" гэж хуульд заасан агуулгаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, хуульд заасан туршлагын шаардлагыг тусгах шаардлага үүссэн болно.

Мөн дэс түшмэлийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын мэргэшлийн шаардлагыг зарим хэсгийг Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан агуулгаар өөрчлөх, хасах зүй ёсны шаардлага гарсан.

#### Хоёр. Актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Тогтоолын 5 хавсралтад холбогдох өөрчлөлт оруулах, 1 хавсралтын холбогдох заалтыг хасах ерөнхий бүтэцтэй.

2.2. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, албан хаагчийг сонгон шалгаруулах, албан тушаалд томилох, шатлан дэвшүүлэх харилцаанд ашиглахаар зохицуулсан бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 23, 24, 29 дүгээр зүйлд заасан агуулгаар зөвхөн мэргэшил, туршлагын хэсэгт өөрчлөлт орсон.

2.3. 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн захиргааны тэргүүн түшмэл 166, эрхэлсэн түшмэл 716, ахлах түшмэл 2505, дэс түшмэл 17233, нийт 20620 байна. Энэ

өөрчлөлтийн хамрах хүрээ нь дээр дурдсан төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс түшмэлийн албан тушаалд тавигдах мэргэшил, туршлагын шаардлагыг хамрах юм.

**Гурав. Акт гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлэг.**

3.1. Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад шаардлагыг бүрэн хангасан албан хаагч, иргэн бүртгэлд хамрагдах байдал эрс цөөрөх хандлагатай асуудлыг шийдвэрлэх талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хандсан бөгөөд тус газрын 2023 оны ХЭГ/574 дугаар албан бичигт "Хууль тогтоомжийн тесөл боловсруулах аргачлал"-д заасан агуулгаар шийдвэрлэх, 2023 оны ХЭГ/663 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолд оруулах өөрчлөлтийг зарчмын хувьд дэмжиж тус тус санал ирүүлсэн болно.

3.2. Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанаас тус зөвлөлийн яам, агентлаг дахь салбар зөвлөлийн гишүүн 150 төрийн албан хаагч, УИХ-ын Тамгын газрын удирдлагын зөвлөлийн гишүүн 19 төрийн албан хаагчдыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулав. /Хэлэлцүүлэгийн тэмдээгээп, танилцуулгыг хавсаргав./

Мөн Яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны 40 албан тушаалтанд "Үр чадварын шилжилт" хэлэлцүүлгийн хүрээнд мөн танилцуулав. Түүнчлэн Удирдлагын академийн холбогдох албан тушаалтуудтай ажил хэргийн хүрээнд санал солилцож нэгтгэсэн болно.

Тогтоолын хавсралтуудад өөрчлөлт оруулснаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөх бүлэг байхгүй, харин ч төрийн захиргааны албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх, албан тушаалын мэргэшлийн болон туршлагын тусгай шаардлагын үзүүлэлт буурч, зерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

**Дөрөв.Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх:**

Тогтоолын хавсралтад оруулж байгаа өөрчлөлт нь хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

Тодруулбал, хүний эрх, эрх чөлөө ялгavarлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгээгүй. Мөн жендерийн эрх тэгш байдлыг хангасан буюу аль нэг хүйст давуу байдал олгоогүй, дотоод болон гадаадын хөренгө оруулалттай аж ахуйн нэгж өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй, өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгохгүй, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, хориг болохгүй, хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөхгүй болно.

**Тав.Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх**

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг төрийн албаны төв

байгууллага батална" гэж заасан. Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн "Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай" 2 дугаар тогтоолыг батлан хүчин төгөлдөр мөрдөж байна.

Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт "Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад" хамруулахаар заасан бөгөөд сургалтыг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага хариуцан зохион байгуулах, сургалтын агуулга, хөтөлбөрийг Засгийн газар тодорхойлооюуд заасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор "Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга" батлагдан хэрэгжиж байна.

**Зургаа. Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага нь өнөө хүртэл хэрэгжиж, төрийн албаны зохих тусгагдсан харилцааг зохицуулж хэвшсэн.

Тогтоолын хавсралтуудад орсон өөрчлөлтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах чиг үүргийг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Төрийн албаны зөвлөлийн яам, агентлаг, аймаг, нийслэл дэх салбар зөвлөл хэрэгжүүлэх бөгөөд шинээр хүний нөөцийн хэрэгцээ үүсэхгүй, төрийн байгууллага байгуулахгүй, төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэхгүй, захиргааны шинэ чиг үүрэг бий болгохгүй.

Дээрх үзүүлэлтүүдээр нөлөөллийн шинжилгээ хийж үзэхэд Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйл, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалтыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолын хавсралтуудад өөрчлөлт оруулах үндэстэй байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**